

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
ЗОРИЛГО. УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ. /"Алсын хараа-2050" зорилт 5.3, "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 5.3, "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.1.1, Улсын бүртгэлийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө/							
Зорилт 1. Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.							
1.1	Улсын бүртгэлийн хэлтэс байрлаж үйл ажиллагаа явуулах "Төрийн үйлчилгээний нэгдсэн төв"-ийн зураг төсөл хийлгэх асуудлыг шийдвэрлэхэд хамтран ажиллах	Орон нутгийн төсөв /300 сая/	Зураг төслийн ажлын гүйцэтгэлийн хувь	0	50	Зураг төслийн ажлын төсөв 300 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгасан.	100%
1.2	Тоон гарын үсэг олголтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	-	Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн тоо	15898	18000	Тайлант хугацаанд 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 3930 иргэнд тоон гарын үсэг олгосон бөгөөд нийт 15783 иргэнд тоон гарын үсэг олгоод байна.	88%
1.3	Улсын бүртгэлийн үйлчилгээг цахим машинаар /Киоск/ үзүүлэх	-	Нэмэгдүүлсэн киоск машины тоо	1	2	Сайншанд сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах Соёмбо цогцолборт, Замын-Үүд сумын Засаг даргын Тамгын газрын байранд Төрийн цахим үйлчилгээний киоск машин тус тус 1 ширхэгийг нэмж байршуулсан ба тус хэлтэс нь өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.	100%

1.4	Үйлчилгээний танхимыг стандартад нийцүүлэх ажлыг зохион байгуулах	Орон нутгийн төсөв	Зохион байгуулсан ажлын тоо	0	1	Тус хэлтэс нь аймгийн Засаг даргад дэмжлэг хүсэх тухай албан хүсэлт хүргүүлсний дагуу орон нутгийн санхүүжилтээр 8.302.250 төгрөгийг шийдвэрлүүлэн Нью компас ХХК-иар үйлчилгээний танхимд үйлчлүүлэх дарааллын "Дугаар олгох" төхөөрөмжийг шинээр суурилуулсан. Үйлчилгээний зааланд 120 000 төгрөгийн үнэ бүхий нийтийн гар утас цэнэглэх хэсэг /charging zone/-ийг байршуулсан. Энэ цэнэглэгч нь нэг дор 6 гар утсыг зэрэг цэнэглэх боломжтой юм.	100%
1.5	Улсын бүртгэлийн Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулахад хүргүүлэх	-	Санал хүргүүлсэн хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн тоо	2	3	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэх маягтын загварыг шинэчлэн боловсруулах, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн системийн шинэчлэл, 2018 оны Иргэний үнэмлэхийн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1.4.4, 1.4.9 дэх заалтад өөрчлөлт оруулах талаар тус тус санал хүргүүлсэн.	100%
			Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн сурталчилгааны тоо	2	3	Хэлтсийн дарга Ц.Тэгшжаргал нь Дорноговь аймгийн DSB телевизд Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн талаар болон Улсын бүртгэлийн хэлтсээс хийж буй онцлог ажлууд, цаг үеийн мэдээ мэдээллийг хийж олон нийтэд сурталчилсан. УБЕГ-ын даргын 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 3/10321 дугаартай "Чиглэл хүргүүлэх" тухай албан бичгийн дагуу Улсын бүртгэлийн үйлчилгээг зөвхөн хурууны хээгээр явуулах болсон талаар иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга Б.Баттуяа агентлагийн дарга нар болон иргэдэд Эд хөрөнгийн эрхийн улсын тасгийн дарга Г.Батсайхан Монгол банк болон арилжааны банкны дарга нарт мэдээлэл өгч ажилласан.	100%

1.6.	Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээ хийх	-	Бүртгэлийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн тоо	0	1	Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээг улсын ахлах бүртгэгч нар оны эхэнд хийсэн. Дээрх бүртгэлийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийснээр тодорхой тооны бүртгэлүүдийн үйл ажиллагааг сайжруулж, улсын бүртгэгч нарын ажлын ачааллыг тэнцвэржүүлсэн.	100%
1.7	Улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, контент бэлтгэж, түгээх	-	Сурталчилсан контентын тоо	0	2	Хуулиар тогтоосон хугацаатай бүртгэлийг хугацаа хоцорч бүртгүүлэх зөрчил арилахгүй байгаатай холбогдуулан тухайн хугацааг сурталчилахаас гадна уг бүртгэлийг хийлгэхэд анхаарах асуудал, бүрдүүлэх материалыг давхар сурталчилж төрсний бүртгэл, 16 насанд хүрч шинээр иргэний үнэмлэх авах, 25, 45 насанд хүрч иргэний үнэмлэхний сунгалт шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэхтэй холбоотой 4 контент бэлтгэн цахимд байршуулж 8500 иргэнд мэдээлэл хүргэсэн.	100%
Зорилт 2. Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.							
2.1.	Улсын бүртгэлийн үйлчилгээг эрхлэн хөтлөх	-	Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр үйлчилгээ үзүүлсэн тоо	34682	34690	Иргэний бүртгэлийн чиглэлээр 40929 бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнд: төрсний бүртгэл 956, гэрлэсний бүртгэл 193, гэрлэлт дуусгавар болсоны бүртгэл 85, үрчилсний бүртгэл 9, эцэг /эх/ тогтоосны бүртгэл 51, овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн өөрчилсний бүртгэл 41, нас барсны бүртгэл 349, регистрийн дугаар өөрчилсний бүртгэл 2, нөхөн бүртгэл 77, засвар өөрчлөлтийн бүртгэл 106, аймаг, нийслэлээс шилжин ирсний бүртгэл 925, сум, баг хооронд 1729 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хийсэн. Нийт олгосон иргэний үнэмлэх 2664 үүнээс шинээр олгосон иргэний үнэмлэх 1014, иргэний үнэмлэхээ гээгдүүлэн дахин олгосон иргэний үнэмлэх 186, иргэний үнэмлэхний хугацаа дуусч 25, 45	100 %

					насны сунгалт хийлгэсэн 1464 иргэдэд иргэний үнэмлэх олгосон. Үндэсний энгийн гадаад паспорт 10314, нэг удаагийн хавсралт 275, Монгол-Хятадын хил орчмын нутагт зорчих үнэмлэх 9625 иргэнд олгосон. Иргэн, хуулийн этгээдэд 7069 лавлагаа олгосон. Үүнээс иргэнд 5706, хууль хяналтын байгууллагад 179, албан хэрэгцээнд 789, дахин олгосон гэрчилгээнд 395 лавлагаа олгосон байна. Тоон гарын үсгийн бүртгэлийг нийт 3795 иргэнд олгосон.	
		Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр үйлчилгээ үзүүлсэн тоо	7359	7360	Тайлант хугацаанд эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхээ бүртгүүлэхээр иргэн, хуулийн этгээдээс 8078 мэдүүлгийг хүлээн авсан байна. Үүнээс: Анхны бүртгэл 425, Өмчлөх эрх шилжих гэрээ 1503, Барьцааны гэрээ 5119, Бүртгэлд өөрчлөлт оруулах 358, Газар өмчлөх анхны бүртгэл 540, Лавлагаа 48. Эдгээр бүртгэлийг бүртгэснээр 152.096.235 төгрөгийн орлого УБХ-ийн дансанд, орон нутгийн орлогод үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны татвар 1.078.790.575 төгрөг, тэмдэгтийн хураамж 10.856.249 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн.	100%
		Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр үйлчилгээ үзүүлсэн тоо	1187	1190	Тайлант хугацаанд 1847 хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэл хийсэн. Үүнд: Шинээр үүсэн байгуулагдсан 352 хуулийн этгээд бүртгэгдсэн байна. Хуулийн этгээдийн бүртгэлийн нэмэлт өөрчлөлтөөр 350 материал хүлээн авч бүртгэлийг хийж хувийн хэрэгт баяжилтыг хийсэн. Тамга тэмдгийн хяналтын дугаар олгосон 451, 60 тамга хураан авч хүчингүй болгосон, иргэн, хуулийн этгээдэд 645 лавлагаа олгосон байна. Хуулийн этгээдийн 570 нэр баталгаажуулалт хийсэн байна. "Шинэ хоршоо" хөдөлгөөн улс даяар хэрэгжсэнтэй холбоотой тус хэлтсийн 14	100%

						сумдын бүртгэгч нар малчдад хуулийн этгээдийн бүртгэлийн талаар мэдээлэл өгч шинээр нийт 160 хоршоог үүсгэн байгуулж мэдээлэлд өөрчлөлт оруулсан.	
2.2.	“Улсын бүртгэлийн үйлчилгээний төв болон цэг”-ийн үзүүлж байгаа үйлчилгээний чанарыг сайжруулах	-	Улсын бүртгэлийн зөөврийн тоног төхөөрөмжөөр үзүүлсэн үйлчилгээний тоо	5	11	Тайлант хугацаанд тус хэлтэс нь зөөврийн 4G сүлжээний төхөөрөмж, компьютерийг ашиглан Дорноговь аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт ял эдэлж байгаа 7 иргэний биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл, 2 иргэний гэрлэсний бүртгэл, Сайншанд, Замын-Үүд сумын Багийн бүртгэл мэдээллийн ажилтантай хамтран хөгжлийн бэрхшээлтэй 3 иргэний биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийг хийсэн. - Хилийн цэргийн 0129 дүгээр ангийн 30 албан хаагч, Хаан банкны 50 албан хаагч, Дорноговь аймаг дахь Шүүхийн 23 албан хаагчдад тус тус тоон гарын үсэг олгосон. - Замын-Үүд сумын ачаа тээврийн компанийн жолооч, Хилийн цэргийн 0108 дугаар ангийн албан хаагч, УБТЗ-ын Замын-Үүд татах хэсгийн ажилтнууд, Замын-Үүд дахь Гаалийн газар гэх мэт албан хаагч нарт хил орчмын нутгаар зорчих үнэмлэх 10373, гадаад паспорт 2888 ширхэгийг, тоон гарын үсэг 414 олгосон.	100%
			Нэмэгдсэн цэгийн тоо 24/7	1	2	Замын-Үүд суманд ЗДТГ-ын байранд 1 ширхэг, Сайншанд суманд Соёмбо цогцолборт 1 ширхэг киоск машиныг тус тус суурьлуулж улсын бүртгэлийн цахим үйлчилгээг 24/7 үзүүлж эхэлсэн.	100%
2.3.	Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх	-	Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцэлсэн хувийн хэргийн тоо	208	250	Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд нөхөн бүртгэл 78, засвар өөрчлөлтийн бүртгэл 117 бүртгэлийг мэдээллийн санд тусган нийт 195 иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцэлсэн.	78%

2.4	Сумдын хамтран ойрхон үйлчилгээ" хэмжээг байгуулах	ЗДТГ-тай "Танд төрийн арга зохион	Сумдад зохион байгуулсан арга хэмжээний тоо	0	5	Тайлант хугацаанд 6 суманд 6 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж ажиллалаа. Үүнд: Сайхандулаан суманд 02 дугаар сарын 01-нд, Өргөн суманд 02 дугаар сарын 23-ны өдөр, Хатанбулаг суманд 04 дүгээр сарын 19, Иххэт суманд 05 дугаар сарын 23-ны өдөр, Улаанбадрах суманд 05 дугаар сарын 17, 30-ны өдрүүдэд нээлттэй хаалганы өдөрлөг, Сайншанд суманд 05 дугаар сарын 01-ний өдөр Хуульчийн пробоно өдөрлөгийг тус тус зохион байгуулж нийт 177 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.	100%
2.5	Аймгийн хэмжээнд шинэчилэгдсэн хаягийн мэдээллийг ГХБХБайгуулалтын газраас гаргуулан авч бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллах	-	Бүртгэл хийхдээ шинэчилэн бүртгэсэн хаягийн тоо	0	50	Шинэчлэгдсэн хаягийн мэдээллийг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас гаргуулан авч эд хөрөнгийн хаяг өөрчлөгдсөн 222 бүртгэлийг хийсэн.	100%
Зорилт 3. Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг ханган, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.							
3.1	Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих замаар улсын бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг хангах	-	Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.	100	100	Бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх төлөвлөгөө боловсруулан батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тайлант хугацаанд хийж гүйцэтгэх ажлуудыг бүрэн хийж дуусгасан. Өргөдөл, санал гомдлын мөрөөр 49 удаа, төлөвлөгөөт хяналт шалгалтыг 5 удаа нийт 54 удаагийн хяналт шалгалтыг хийсэн. Өдөр дутмын болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг тогтмол хийж иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 1571, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 657, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 76, архивын чиглэлээр 241 нийт 2545 бүртгэлд	100%

						хяналт шалгалт хийж 330 зөрчил илрүүлж арилгуулах арга хэмжээ авч ажилласан байна. Зөрчлийн тухай хуулиар 264 иргэн, 7 хуулийн этгээдэд нийт 8.590.000 төгрөгийн торгууль оногдуулсан.	
3.2	Байгууллагын төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулах, тайлагнах, шилэн дансанд байршуулах	-	Шилэн дансанд тайлагнасан мэдээллийн мөнгөн дүн	1000.0 сая.төг	1000.0 сая.төг	Шилэн дансаны тухай хуулийн дагуу 11 сарын байдлаар 4159923.7 мянган төгрөгийн мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан.	100%
			Хугацаандаа байршуулсан шилэн дансны мэдээллийн тоо.	3665	3665	Шилэн дансны тухай хуулийн дагуу тайлант хугацаанд 654 мэдээлэл байршуулахаас 654 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан.	100%
3.3	Санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмжгүй ажиллах, аудитын дүгнэлтийн хэрэгжилтийг хуулийн хугацаанд хүргүүлэх	-	Биелэлтийг аудитын дүгнэлтэд заасан хугацаанд нь хүргүүлсэн тоо	1	1	Хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан бөгөөд аудитын дүгнэлт гараагүй, санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил байхгүй болно. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжилт сонгууль, Аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийг зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын санхүүжилт, гүйцэтгэлд хийсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчилгүй ажилласан болно.	100%
3.4.	Үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, дүн шинжилгээ хийж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулах	-	Үйлчлүүлэгчдээс судалгаа авч, дүн шинжилгээ хийсэн тоо	0	4	Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдалд дүн шинжилгээ хийх зорилгоор тайлант хугацаанд 4 удаа 400 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. Судалгаанд хамрагдсан иргэдээс 74 хувь нь хүссэн үйлчилгээгээ авч чадсан, 24 хувь нь зөвөлгөө, мэдээлэл авдаг, 2 хувь нь ачаалал ихтэй байна гэж хариулсан нь иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар сайжирч, албан хаагчийн харилцаа, хандлага мэргэшил, мэргэжлийн ур чадвар сайжирсныг харуулж байна. Мөн үйл ажиллагааны мэдээллийг нийт судалгаанд	100%

						хамрагдсан иргэдийн 34 хувь нь вейб сайт, 26 хувь нь facebook буюу цахим хуудаснаас 27 хувь нь хамтран ажиллагсад, үлдсэн хувь нь мэдээллийн самбар, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, гэр бүл найз нөхдөөсөө авдаг гэсэн байна.	
3.5	Цахим мэдээллийн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээний хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг ханган ажиллаж, сервер, сүлжээний тоног төхөөрөмжийн эд ангийн засвар үйлчилгээг хийж гүйцэтгэх	-	Засвар үйлчилгээ хийж, хэвийн ажиллагааг хангасан тоо	20	22	Цахим мэдээллийн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээний хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг ханган Мандах сумын медиа хувиргуур, Замын-Үүд, Мандах сумын рүүтерийн болон ракин тэжээлийн залгуур, Иххэт, Хөвсгөл, Замын-Үүд, Өргөн, Мандах сумын суурин компьютерийн BIOS-ын батерей, Хяналтын улсын байцаагчийн дотоод сүлжээний свичийг шинээр сольж хэвийн ажиллагаанд оруулсан. Ахлах нягтлан бодогч, мэдээлэл технологийн ажилтан, Хөвсгөл, Замын-Үүд, Сайншанд сумын суурин компьютер, 9 ширхэг зөөврийн компьютерийг форматлаж, Сайншанд сумын HP MFP M428FDW, архивчийн компьютерийн утасгүй гарыг засаж хэвийн ажиллагаанд оруулсан. Иргэний улсын бүртгэлийн тасгийн тогны разетка, урт залгууруудыг сольж янзлан хэвийн ажиллагаанд оруулсан. Улсын бүртгэлийн цахим КИОСК машиныг Соёмбо цогцолборт дотоод сүлжээ татаж ажиллагаанд оруулсан. Сонгуулийн хорооны 75 хэсэг дээр очиж Улсын бүртгэлийн сүлжээг шалгаж хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.	100 %

3.6	Хэлтсийн албан хэрэгцээнд ашиглаж буй тоног төхөөрөмж, техник хэрэгслийг шинэчлэх	Орон нутгийн төсөв 6 сая	Шинэчилсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн тоо	0	5	Тус хэлтсийн дарга Ц.Тэгшжаргал Аймгийн Засаг дарга О.Батжаргалтай уулзан хэлтсийн албан хэрэгцээнд ашиглаж буй тоног төхөөрөмж, техник хэрэгслийг шинэчлэх хүсэлт хүргүүлсний дагуу Аймгийн Засаг даргын 2024 оны "Дэмжлэг үзүүлэх тухай" А/406 тоот захирамжаар тус хэлтэст 19 832 050 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Тус дэмжлэгээр хэлтсийн үйл ажиллагаанд нэн шаардлагатай дараах тоног төхөөрөмжийг худалдан авсан. Үүнд: • Ньюкомпас ХХК-аас 8 302 250 төгрөгөөр "Дугаар дуудагч киоск" машин • Би Си Ти ХХК-аас Olivetti PR2 Plus принтер 2 ширхэг • ЭДанс ХХК-аас Dell vostro 3020 tower core i5 суурин компьютер 2 ширхэг, Dell display 24 inch дэлгэц 2 ширхэг • Сервис зоне ХХК-аас Epson L850 өнгөт принтер 1 ширхэг	100%
Зорилт 4. Хуулиар олгосон тусгай чиг үүргийг хэрэгжүүлнэ.							
4.1.	МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг ханган ажиллах.	-	Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан ажлуудыг 100 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлэн ажилласан.	100%
4.2.	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг ханган ажилласан.	-	Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийн дагуу ажлуудыг 100 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлэн ажилласан.	100%

Зорилт 5.Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.

5.1.	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжид шилжүүлэх.	ADB төсөл	Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх боломж бүрдсэн сумдын тоо	4	6	Улсын бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжид шилжүүлэх, иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны Б/297 дугаар тушаалаар 8 сумын улсын бүртгэгчид эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх нээлгэсэн бөгөөд тайлант хугацаанд 870 бүртгэл хөтөлсөн. 2024 оны Б/298 дугаар тушаалаар 11 сумын улсын бүртгэгчид хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх эрхийг нээлгэж тайлант хугацаанд Мандах сум 29, Өргөн сум 34, Айраг сум 24, Даланжаргалан сум 49, Дэлгэрэх сум 73, Иххэт сум 23, Сайхандулаан сум 8, Хөвсгөл сум 13, Эрдэнэ сум 26 нийт 279 бүртгэл хийж хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд оруулсан байна.	100%
Зорилт 6. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.							
6.1.	Улсын бүртгэлийн ерөнхий газрын авлигын эрсдэлийг бууруулах хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх. /2.6.2.3./	-	Хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө боловсруулж батлуулж, хэрэгжүүлэн ажиллах	0	1	Улсын бүртгэлийн байгууллагын Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан 16 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг хэлэлцүүлэн баталж, хэрэгжилтийг хангуулан ажилласан. Тайлант хугацаанд албан хаагчтай холбоотой авилга хээл хахууль, ашиг сонирхлын талаар гомдол мэдээлэл ирээгүй ба албан хаагчид хууль заасан хугацаанд ХАСХОМ-ийг гаргасан болно.	100%

6.2	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	-	АТГ-аас бэлтгэсэн инфографик, видео нийтлэл, тв шторк, график, хөдөлгөөнт зураг, цахим ном, зурагт хуудас, теле зохиомж, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд хүргэсэн тоо	1	10	Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн “Авлигын эсрэг нэгдье” тв шторк инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг зэргийг тус хэлтсийн үйлчилгээний танхимд дэлгэцээр тогтмол явуулан иргэд, олон нийтэд хүргэн ажиллаж байна. Мөн Соёмбо цогцолборын үүдэнд, үйлчилгээний заалны хананд “Авилгын эсрэг НЭГДЬЕ” гэсэн шторк хуудсыг мэдээллийн самбарт байршуулж иргэд олон нийтэд хүргэн ажиллалаа. Хяналтын улсын байцаагч, бичиг хэргийн ажилтны өрөөний үүдэнд болон архивын өрөөний гадна хаалганд “АВИЛГА АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ХАМТ ОЛОН” гэсэн сурталчилгааны хуудсыг наан байршуулсан. Хэлтсийн албан хаагчдын авилга хээл хахууль, хүнд сурталын талаар мэдээлэл хүлээн авах 7052-2200 дугаарыг байршуулсан.	100%
			АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг байгууллагын хэмжээнд зохион байгуулсан тоо	0	2	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчилах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” тусгай дугаарыг үйлчилгээний заалны гадна шилэн хаалга болон хяналтын улсын байцаагч, бичиг хэргийн ажилтны өрөөний хаалганд наан байршуулсан. Мөн хэлтсийн мэдээллийн самбрын Авилгын эсрэг хамтдаа цэсэнд “БИД АВИЛГА АВАХГҮЙ, БИД АВИЛГА ДЭМЖИХГҮЙ” гэсэн зурагт хуудсыг наан, хэлтсийн албан хаагчдын авилга хээл хахууль, хүнд сурталын талаар мэдээлэл хүлээн авах 7052-2200 утасны дугаарыг байршуулсан.	100%

Зорилт 7. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.

7.1.	Байгууллагын 2024 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	-	Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	Улсын бүртгэлийн ерөнхий газраас баталсан сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан 17 арга хэмжээ бүхий сургалтын төлөвлөгөөг хэлэлцүүлэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд 22 сургалтанд давхардсан тоогоор 201 алба хаагчид хамрагдсан	100%
7.2.	Хэлтсийн алба хаагчдыг улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системд тавигдсан сургалт мэдээлэлтэй тухай бүр танилцах, шалгалт өгөх ажлыг зохион байгуулах	-	Цахим хичээлийг судлан шалгалт өгсөн алба хаагчдын тоо	23	24	Хэлтсийн 26 алба хаагч улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системд тавигдсан сургалт мэдээлэлтэй тухай бүр танилцаж, бие даах хичээл болон чиглэл, үүрэг даалгаврыг бүрэн судалж шалгалтыг 85-100 хувийн амжилттай өгсөн. Шинээр томилогдсон 3 улсын бүртгэгчид хүний нөөц, сургалтын нэгдсэн системд нэвтрэх эрхийг нээлгэж, хичээлийг судлуулсан.	100%
7.3	Хэлтсийн хэмжээнд ажиллаж байгаа эрх зүйч бус улсын бүртгэгчдийг эрх зүйч мэргэжилтэй болгох	-	Эрх зүйч мэргэжилтэй болсон улсын бүртгэгчийн тоо	19	22	Тус хэлтэст 2023 онд 19 эрх зүйч мэргэжилтэй албан хаагч ажиллаж байсан. Тайлант хугацаанд 3 улсын бүртгэгч шинээр эрх зүйч мэргэжлээр суралцаж төгсөн дипломоо гардан авч нийт 22 эрх зүйч мэргэжилтэй албан хаагчтай болсон.	100%

Төлөвлөгөөг үнэлсэн:

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

(албан тушаал)

Тэмдэг

Төсвийн шууд захирагч

..... /У.БОЛДХҮҮ/

(гарын үсэг)

(огноо)

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА

(албан тушаал)

Нэгжийн дарга

..... /Т.ГАНТӨМӨР/

(гарын үсэг)

(огноо).....

Тайлагнасан:

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

(албан тушаал)

Нэгжийн дарга

..... /Ц.ТЭГШЖАРГАЛ/

(гарын үсэг)



21

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
ЦАБШИРЫН ТЭГШЖАРГАЛЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН
ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Улсын бүртгэлийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
1.	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	93	65, 1

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Арга хэмжээ 1 Уйгаржин монгол бичгийг бие даан судлан суралцах	100	15
2.	Арга хэмжээ 2 УБЕГ болон Төрийн албаны зөвлөл, Орон нутгийн захиргааны байгууллагаас зохион байгуулж буй цахим болон танхимын сургалт, семинаруудад тогтмол оролцох	100	15
3	Арга хэмжээ 3 Хүний нөөц сургалтын нэгдсэн системд байршуулсан цахим сургалтад хамрагдах	100	15
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			15

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	15
2.	Удирдан зохион байгуулах	15
3.	Асуудал шийдвэрлэх	15
4.	Манлайлах	10
5.	Багаар ажиллах	15
6.	Харилцаа	15
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7.	Мэргэжлийн ур чадвар 1.	15

8.	Мэргэжлийн ур чадвар 2.	15
9.	Мэргэжлийн ур чадвар 3.	15
	Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо	14,4

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)	70 хүртэлх оноо 65,1
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15 хүртэлх оноо 15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15 хүртэлх оноо 14,4
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	 оноо
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		94,5

Үнэлгээ өгсөн:

УЛСЫН БҮРТГЭЛИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



У.БОЛДХҮҮ

(огноо)

Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:

Нэгжийн дарга:

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.ТЭГШЖАРГАЛ

(огноо)